



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 297

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хувийн хэвшлийн хуулийн этгээдийн өөрийн хүсэлтээр төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн, нийт 277,126,600.00 (хоёр зуун далан долоон сая нэг зуун хорин зургаан мянга зургаан зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Ариун-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001644

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13-н өдрийн
...2023... дугаар тогтоолын хавсралт

"Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Байгууллагын нэр	Объектын нэр, байршил	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Бүртгэх нийт дүн (төгрөгөөр)
1	Халаалтын ялтсан бойлер 200 кВт	"Сайхан булган" ХХК	Багануур дүүрэг, 3-р хороо, Наран хороолол	2024	ком	12,000,000.00	1	12,000,000.00
2	Эргэлтийн насос 7.2 м3/цаг			2024	ш	4,850,000.00	2	9,700,000.00
3	Халаалтын ялтсан бойлер 290 кВт			2024	ком	14,000,000.00	1	14,000,000.00
4	Насос 0.7 м3			2024	ш	2,800,000.00	2	5,600,000.00
5	Даралт барих систем			2024	ш	10,293,100.00	1	10,293,100.00
6	Дулааны тоолуур /Ultraheat uh50/			2024	ком	5,200,000.00	1	5,200,000.00
7	Нэмэлт усны тоолуур СВТУ10М М2	"Гэрэл цамхаг констракшн" ХХК	Багануур дүүрэг, 1-р хороо	2024	ком	1,100,000.00	1	1,100,000.00
8	Удирдлагын самбар			2024	ком	12,000,000.00	1	12,000,000.00
9	ф219 мм шугам хос			2024	м	1,033,000.00	134	138,422,000.00
10	ф80 мм шугам хос			2024	м	623,000.00	30	18,690,000.00
11	ДУ 200 хаалт			2024	ш	2,535,950.00	2	5,071,900.00
12	ДУ80 хаалт			2024	ш	352,000.00	4	1,408,000.00
13	Дулааны худаг			2024	ш	5,000,000.00	2	10,000,000.00
14	Дулааны дамжуулах төв ЦТД №10				ком	33,641,600.00	1	33,641,600.00
Нийт дүн				2024			1	277,126,600.00